

## Аймгийн төв номын санд 1000 гаруй судар бичиг бий

ОРОН НУТГИЙН МЭДЭЭ | ДОРНОД

Дэлгэрмаа.Д

167@montsame.mn

2021-09-20 15:45:54

Дорнод /МОНЦАМЭ/. Цэндийн Дамдинсүрэнгийн нэрэмжит Төв номын санд 200-300 жилийн настай 1000 гаруй судар бичиг бий. Төв номын сангийн хамт олон энэхүү судар бичгүүдээ бүртгэлжүүлж хаягжуулах зорилгоор МУБИС-ийн Монгол хэлний тэнхимийн багш, хэл бичгийн ухааны доктор, дэд профессор Д.Ганболд, доктурлант М.Гэрэлсүрэн нарыг урьж ажиллуулж байна. Дээрх судар бичгүүдийн дийлэнх нь шашны холбогдолтой бүтээлүүд аж.

Төв номын сангийн захирал Ж.Цагаан: "Өмнө нь бид баринтагтай судар бичгүүдээ тоолж 300 орчим гэж барагцаалж байсан. Гурван жилийн турш хөөцөлдөж хөрөнгө мөнгө тусгуулснаар мэргэжлийн эрдэмтдийг урьж авчраад байна. Судруудын нэр тодорсноор код шифртэй болгож, цахим каталогжуулна. Үүний үр дүнд дэлхийн аль ч өнцгөөс судалгааны ажил хийж байгаа эрдэмтэд үзэж танилцах боломж бүрдэнэ" гэв.

Эрдэмтэд судар бичгүүдийг нэг бүрчлэн уншиж судлан, нэр хаягийг нь тэмдэглэж байгаа юм. Эхний удаад 300 гаруй судар бичгийг хаягжуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Эх сурвалж: <https://montsame.mn/mn/read/275613>